

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 25-ны өдөр

Дугаар №21/01

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг үндэслэн тус тус **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай. Үүнд:

ТУЗ-ийн энгийн гишүүнээр:

1. А.Хадбаатар
2. Б.Пүрэвжаргал
3. Б.Сугарсүрэн
4. Б.Насан-Эрдэнэ
5. Б.Одмаа
6. Э.Болор-Эрдэнэ

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай. Үүнд:

1. С.Отгонбилэг
2. Г.Мөнхбаяр
3. О.Нандинчимэг

3. Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэн компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг ТУЗ-ийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.СУГАРСҮРЭН/

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12-р сарын 25-ны өдөр

Дугаар №21/02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Люкс Занаду Групп ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 2.2–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй:

“ХК нь шаардлагатай тохиолдолд хууль, журмын дагуу төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна”

2. Компанийн дүрэмд 2.4–р зүйлийг нэмж оруулсугай:

“Компанийн тухай хуулийн 6.7-д заасан эрхийн дагуу охин компанийн хувьцаа эзэмшигчдийн гаргасан гомдлын дагуу охин компанийн өрийг хамтран хариуцахаар шүүхийн шийдвэрээр тогтоосноос бусад тохиолдолд охин компанийн өрийг хариуцахгүй”

3. Компанийн дүрмийн 3.3.1–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй:

“Байгалийн болон таримал ургамал, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн толгой компанийн үйл ажиллагаа; 7010”

4. Компанийн дүрмийн 3.3.2–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй:

“Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа; 7010”

5. Компанийн дүрмийн 3.4–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй:

“Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор бэлтгэлийн нэгдсэн сүлжээнд оролцогч болон хувьцаа эзэмшигчдэд санхүүгийн, менежмент, хөрөнгө оруулалт хийх замаар хуримтлал бий болгох мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах зэргээр хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулна”

6. Компанийн дүрмийн 7.10–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй:
“Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийг сонгоно. ТУЗ нь компанийн болон охин компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ”
7. Компанийн дүрэмд 7.23.21–р зүйлийг нэмж оруулсугай:
“Охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх”
8. Компанийн дүрмийн 7.37.1–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй
“Компанийн болон охин компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих”
9. Компанийн дүрмийн 7.38.1–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй:
“ТУЗ-ийн гишүүн, компанийн болон охин компанийн гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоож, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгах”
10. Компанийн дүрмийн 7.38.5–р зүйлийг дараах байдлаар өөрчилсүгэй:
“Компанийн болон охин компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох”
11. Компанийн дүрмийн 7.41.1–р зүйлд дараах байдлаар өөрчилсүгэй:
“Компанийн болон охин компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих”
12. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэх, Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Ж.Үүрийнтуяа)-д даалгасугай:

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА**



Б.СҮТАРСҮРЭН

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 25-ны өдөр

Дугаар № 21/03

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 21/02 дугаар тогтоолыг үндэслэн тус тус **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн сар бүрийн төсөв 9,600,000 төгрөг байх бөгөөд үүнд ТУЗ-ийн гишүүний сарын цалин 1,000,000 төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын сарын цалин 500,000 төгрөг, сар бүрийн Хангамжийн зардал 100,000 төгрөг байхаар баталсугай.
2. Уг тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Сугарсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.СУГАРСҮРЭН/